



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Булган сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/16/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2021 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Аудитын менежер: Утас: 7058-4207 Аудитор: Утас: 7000-3775	Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn И.Сэмжидмаа Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Э.Нандинчимэг Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com
--	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ДОА	Дорнод аймаг
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд



Агуулга

1. Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл.....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	11
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	13



1. Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэргэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 295

танай _____-ны № _____-т

ДОРНОД АЙМГИЙН БУЛГАН
СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Б.ШАРХҮҮХЭН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Булган сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Булган сумын цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дорнод аймгийн Булган сумын цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

011020272



Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,766,578.70	38,819,542.70
35	БАРАА МАТЕРИАЛ	36,766,578.70	38,819,542.70
351	Түүхий эд материал	-	220,000.00
35130	Эм боох материал	-	220,000.00
354	Хангамжийн материал	36,686,578.70	38,599,542.70
35410	Бичиг хэргийн материал	1,666,688.00	280,520.00
35420	Аж ахуйн материал	23,338,148.00	25,418,640.00
35460	Хүнсний материал	-	993,040.00
35470	Бусад хангамжийн материал	11,681,742.70	11,907,342.70
35600	Мал амьтад	80,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	434,092,229.24	474,574,097.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	434,092,229.24	474,574,097.04
392	Биет хөрөнгө	428,092,229.24	468,574,097.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	392,227,282.11	392,227,282.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	(7,263,468.24)	(14,526,936.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25,929,230.00	44,374,245.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,621,980.02)	(21,269,563.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,373,507.82	56,561,987.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,234,696.83)	(31,775,389.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,227,406.00	50,873,649.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(5,545,051.60)	(7,891,177.36)
393	Биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
39301	Програм хангамж	282,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(282,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	6,000,000.00	6,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	470,858,807.94	513,393,639.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	(0.00)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	(0.00)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	470,858,807.94	513,393,639.74
51	Засгийн газрын хувь оролцоо	470,858,807.94	513,393,639.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	623,778,413.00	623,778,413.00
51101	Өмч: - төрийн	623,778,413.00	623,778,413.00
512	Хуримтлагдсан үр дүн	(211,301,558.78)	(168,766,726.98)
51210	Өмнөх үеийн үр дүн	(206,486,933.50)	(211,301,558.78)
51220	Тайлант үеийн үр дүн	(4,814,625.28)	42,534,831.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	58,381,953.72	58,381,953.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	470,858,807.94	513,393,639.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	198,100,800.00	277,181,508.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,471,800.00	54,461,908.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,471,800.00	54,461,908.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,471,800.00	54,461,908.00
1200045	Үнэ төлбөргүй худалдан авсан орлого	9,471,800.00	54,461,908.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,629,000.00	222,719,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	169,029,000.00	202,805,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	169,029,000.00	202,805,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,100,000.00	19,914,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,100,000.00	19,914,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	202,915,425.28	234,643,626.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	202,915,425.28	234,643,626.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	202,899,787.28	227,152,998.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,806,500.00	149,515,500.00
210101	Үндсэн цалин	105,275,900.00	114,857,400.00
210102	Нэмэгдэл	6,392,700.00	21,395,958.74
210104	Урамшуулал	10,137,900.00	13,262,141.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,950,800.00	19,538,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,006,700.00	13,558,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,700.00	1,495,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,900.00	1,196,100.00
210204	Ажилгүйшлийн даатгал	247,200.00	299,000.00
210205	Эрүүд мэргийн даатгал	2,472,300.00	2,990,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,237,969.00	15,667,925.00
210301	Гэрэл, цахилгаан	3,221,969.00	2,551,150.00
210302	Түлш, халаалт	9,116,000.00	11,706,775.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	1,410,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,260,740.00	7,363,596.00
210401	Бичиг хэрэг	778,660.00	886,400.00
210402	Тээвэр, шатахуун	113,280.00	1,164,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	494,200.00	444,400.00
210406	Бага үнэтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	874,600.00	1,811,200.00
210408	Бараа материал ахалсны зардал	-	3,057,596.00
2105	Нормативт зардал	27,822,253.00	16,835,507.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	80,000.00
210502	Хоол, хүнс	27,672,253.00	12,956,307.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,799,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,848,000.00	550,400.00
210604	Урсгал засвар	4,848,000.00	550,400.00
2107	Томилголт, зочны зардал	-	450,000.00
210702	Дотоод албан томилголт	-	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,000.00	470,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,593,525.28	16,761,370.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,004,288.10	1,594,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,589,237.18	15,166,870.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,638.00	7,490,628.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,607.00	4,788,053.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,607.00	4,788,053.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,031.00	2,702,575.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,031.00	2,702,575.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(4,814,625.28)	42,537,881.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	3,050.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	3,050.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(3,050.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(4,814,625.28)	42,534,831.80

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	188,629,000.00	222,719,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	188,629,000.00	222,719,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	169,029,000.00	202,805,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	169,029,000.00	202,805,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	18,100,000.00	19,914,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	18,100,000.00	19,914,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	188,629,000.00	222,719,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,629,000.00	222,719,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	188,613,362.00	215,228,972.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,806,500.00	149,515,500.00
210101	Үндсэн цалин	105,275,900.00	114,857,400.00
210102	Нэмэгдэл	6,392,700.00	21,395,958.74
210104	Урамшуулал	10,137,900.00	13,262,141.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,950,800.00	19,538,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,006,700.00	13,558,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,700.00	1,495,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,900.00	1,196,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,200.00	299,000.00
210205	Эрүүд мэндийн даатгал	2,472,300.00	2,990,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,237,969.00	15,667,925.00
210301	Гэрэл, пахилгаан	3,221,969.00	2,551,150.00
210302	Түлш, халаалт	9,116,000.00	11,706,775.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	1,410,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,360,740.00	6,744,300.00
210401	Бичиг хэрэг	778,660.00	886,400.00
210402	Тээвэр, шатахуун	113,280.00	1,164,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	494,200.00	444,400.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	249,500.00
210406	Бага үнэтэй, гургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	874,600.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	27,822,253.00	18,198,547.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	450,000.00
210502	Хоол, хүнс	27,672,253.00	13,949,347.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	3,799,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,848,000.00	1,544,000.00
210604	Урсгал засвар	4,848,000.00	1,544,000.00
2107	Томиллолт, зочны зардал	-	450,000.00
210702	Дотоод албан томиллолт	-	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,000.00	470,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,207,100.00	3,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	2,207,100.00	3,100,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,638.00	7,490,628.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,607.00	4,788,053.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,607.00	4,788,053.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,031.00	2,702,575.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,031.00	2,702,575.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-211,301,558.78	0.00	470,858,807.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-211,301,558.78	0.00	470,858,807.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
Тайлант үеийн үр дүн					0.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-211,301,558.78	0.00	470,858,807.94
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-211,301,558.78	0.00	470,858,807.94
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-211,301,558.78	0.00	470,858,807.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	42,534,831.80	0.00	42,534,831.80
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	623,778,413.00	58,381,953.72	-168,766,726.98	0.00	513,393,639.74

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	215,228,972.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	215,228,972.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	215,228,972.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,806,500.00	121,806,500.00	149,515,500.00	149,515,500.00
210101	Үндсэн цалин	105,275,900.00	105,275,900.00	114,857,400.00	114,857,400.00
210102	Нэмэгдэл	6,392,700.00	6,392,700.00	21,666,400.00	21,395,958.74
210104	Урамшуулал	10,137,900.00	10,137,900.00	12,991,700.00	13,262,141.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,950,800.00	15,950,800.00	19,538,700.00	19,538,700.00
210201	Тэтгэврийн даатгал	11,006,700.00	11,006,700.00	13,558,100.00	13,558,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,235,700.00	1,235,700.00	1,495,200.00	1,495,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	988,900.00	988,900.00	1,196,100.00	1,196,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	247,200.00	247,200.00	299,000.00	299,000.00
210205	Эрүүд мэндийн даатгал	2,472,300.00	2,472,300.00	2,990,300.00	2,990,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,252,000.00	13,237,969.00	18,369,800.00	15,667,925.00
210301	Гэрэл, цахилгаан	3,236,000.00	3,221,969.00	3,660,000.00	2,551,150.00
210302	Тулш, халаалт	9,116,000.00	9,116,000.00	11,709,800.00	11,706,775.00
210303	Цэвэр, бохир ус	900,000.00	900,000.00	3,000,000.00	1,410,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,362,300.00	2,360,740.00	6,711,800.00	6,744,300.00
210401	Бичиг хэрэг	778,700.00	778,660.00	886,400.00	886,400.00
210402	Гэвэр, шатахуун	114,000.00	113,280.00	1,164,000.00	1,164,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495,000.00	494,200.00	411,400.00	444,400.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	250,000.00	249,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	874,600.00	874,600.00	4,000,000.00	4,000,000.00
2105	Нормативт зардал	27,822,300.00	27,822,253.00	22,983,100.00	18,198,547.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	150,000.00	150,000.00	450,000.00	450,000.00
210502	Хоол, хүнс	27,672,300.00	27,672,253.00	18,733,100.00	13,949,347.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	-	3,800,000.00	3,799,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,848,000.00	4,848,000.00	1,544,700.00	1,544,000.00
210604	Урсгал засвар	4,848,000.00	4,848,000.00	1,544,700.00	1,544,000.00
2107	Томилголт, зочны зардал	-	-	486,000.00	450,000.00
210702	Дотоод албан томилголт	-	-	486,000.00	450,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,000.00	380,000.00	470,000.00	470,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200,000.00	200,000.00	200,000.00	200,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00	270,000.00	270,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	707,100.00	707,100.00	3,100,000.00	3,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	707,100.00	707,100.00	3,100,000.00	3,100,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	222,719,600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	222,719,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	187,129,000.00	187,113,362.00	222,719,600.00	222,719,600.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээн Булган сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Шархүүхэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-аас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Улаанбаатар хот дахь Хаан консалтинг Аудит ХХК-ийн аудитор Э.Нандинчимэж хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын Цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын Цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль бусад холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаалын шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Цэцэрлэгийн насны хүүхдийг асрах, хамгаалах цогц үйл ажиллагаагаар бие бялдар, оюун ухааныг нийгэмшүүлэн хөгжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт дотоод аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Булган сумын Цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 234,647.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар тооцон 4,693.0 мянган төгрөгөөр тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 42,534.8 мянган төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	36,766.5	38,819.5	2,052.9
Үндсэн хөрөнгө	495,039.4	550,037.2	54,997.7
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(60,947.1)	(75,463.1)	(14,515.8)
Нийт хөрөнгө	470,858.8	513,393.6	42,534.8
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	470,858.8	513,393.6	42,534.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	470,858.8	513,393.6	42,534.8

Бараа материалын дансны үлдэгдэл 38,819.5 мянган төгрөг болж 2,052.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сургалтын хэрэгсэл, бараа материал авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 550,463.1 мянган төгрөг болж 54,997.7 мянган төгрөгөөр өссөн нь ИТХ-ын тогтоолын дагуу 654.1 мянган төгрөгийн биет бус хөрөнгө программ акталж, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 55,651.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 654.1 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Булган сумын Цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 79,080.7 мянган төгрөгөөр буюу 39.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 31,278.2 мянган төгрөгөөр буюу 15.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.



Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 222,719.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 222,719.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 222,719.6 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 222,719.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 215,228.9 мянган төгрөгийг зарцуулж, 7,490.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 215,228.9 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байна. Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 169,054.2 мянган төгрөг буюу 76.8 хувийг эзэлж байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 139 мэдээлэл оруулснаас хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцорч 9 мэдээлэл оруулсан байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Дараа жилийн төсвийн төслийн 466,731.0 мянган төгрөгийн мэдээллийг хугацаа хоцорч байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

2019 оны Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 535,293.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 535,293.9 мянган төгрөгийн зөрчилд 535.1 мянган төгрөгийн төлбөрийн акт 1 тогтоож, 534,758.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 535,293.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 535.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 534,758.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд зарцуулсан шатахууны зардлыг ЗТХС-ын 2019 оны 390 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заагдсан автомашины 100км-т зарцуулах жишиг нормоор дахин тооцоолоход 535.1 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт хүргүүлэв.

2. Худалдан авалтын үнийн гэрээний үнэ болон тендерийн үнийн саналтай харьцуулахад 13,541.3 мянган төгрөгийн зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай



хуулийн 41 дүгээр зүйлсийн 2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Тайлант оны эцэст 513,393.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн тооллогыг хангалтгүй чанаргүй хийсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”, 12.2.1-т “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 12.2.2-т “эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед”, УСНББОУС 1-Санхүүгийн тайлангийн толилуулгад нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

4. Тайлант хугацаанд гарсан зардлаас 7,823.9 мянган төгрөгийн зардлыг и-баримт цахим системд бүртгүүлээгүй нь СС-ын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрөх гэсэн тушаалыг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хөрөнгийн тооллогыг чанартай бодитоор хийхгүй байгааг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудалд авч үзлээ.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.25			ДОА-2021/16/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймгийн Булган сумын Цэцэрлэг		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн хөрөнгийн тооллогын баримт шаардлага хангахгүй./маш замбараагүй/ Бараа материал тооллогоор 39,960,530.6 мянган төгрөг, Балансаар 38,819,542.7 мянган төгрөг, дэлгэрэнгүй бүртгэл 41,020,230.7 мянган төгрөг гэсэн 3 өөр дүнтэй тусгагдсан байна. Нийт хөрөнгийн дүн 513,393.6 мянган төгрөг байна.	513,393.6	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Шархүүхэн Д.Балжинням
2	Нийт 130 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба 9 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Хугацаа хоцорсон дараах мэдээллүүд байгаа бөгөөд нийт дүн нь 466,731.0 мянган төгрөг байна. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр) Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр) Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл (Тухай бүр) Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл (Тухай бүр) Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр,	0.0	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Шархүүхэн Д.Балжинням



	авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр)				
3	Хүүхдийн хоолны хүнсэнд 13,949.3 мянган төгрөгийн худалдан авалтыг хийснээс иргэн Д.Должинжавтай хийсэн 408.0 мянган төгрөгийн гэрээ байсан. иргэн Г.Ган-Эрдэнэ, Жинст цацрал ХХК, Ольхон ХХК-тай хийсэн гэрээнүүд хийсэн байна. Худалдан авалтын нийт үнийн дүнг гэрээний жагсаалт дахь үнэтэй харьцуулахад 13,541.3 мянган төгрөг зөрүүтэй байна.	13,541.3	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Шархүүхэн Д.Балжинням
4	Харилцахаас 45,756.7 мянган төгрөгийн зардал төлөгдсөнөөс 7,823.9 мянган төгрөгийн баримт цахим төлбөрийн системд бүртгэгдээгүй байна.	7,823.9	Албан шаардлага өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Шархүүхэн Д.Балжинням
5	Батлагдсан төсөв 1,164.0 мянган төгрөг, Зарцуулалт хэтрээгүй ч, жишиг нормоор тооцоолоход 466.2 мянган төгрөгийн илүү зарцуулалттай. АШБ-гүй 10.2 мянган төгрөг, Норм тооцох боломжгүй/хүчин төгөлдөр бус АШБ/ 68.9 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан гүйлгээ байна.	535.1	Төлбөрийн акт тогтоох	Цэцэрлэгийн эрхлэгч Нягтлан бодогч	Б.Шархүүхэн Д.Балжинням
ДҮН		535,293.9			